

ЭРХ ХЯЗГААРЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

LAW OF LIMITATION OF ACTIONS REGULATION AND IMPLEMENTATION



Б.Отгончимэг

Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгч, ахмад

Товч утга: Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээний тухай ойлголт, эрүүгийн ялын зорилгыг хангахад хүний болон иргэний тодорхой эрхүүдийг хязгаарлах шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг хөндөхийг зорилоо.

Abstract: The concept of coercive measures to impose duties and rights, and to meet the goals of criminal punishment, aims to address the problems in the execution of decisions to limit certain human and civil rights

Түлхүүр үгс: Эрх хязгаарлах, үүрэг хүлээлгэх, албадлагын арга хэмжээ, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт

Keywords: restriction of rights, commit, coercive measures, legal regulation, implementation

Шинэчлэн батлагдсан эрүүгийн хуулийн онцлог нь гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах эрүүгийн хариуцлагыг нэмэгдүүлсэн шинэлэг өөрчлөлтүүдийг бий болгосон явдал юм. Тухайлбал, хорих ялыг биечлэн эдлүүлэх явдлыг багасгах чиглэлд анхаарч, зорчих эрхийг хязгаарлах ял, албадлагын арга хэмжээ, гэм буруугаа хүлээсэн хүнд ял хөнгөрүүлэх, чөлөөлөх албадлагын арга хэмжээ хэрэглэх, хуулийн этгээдэд болон өсвөр насны хүнд оногдуулах ял гэсэн шинэлэг институтийг оруулсан билээ.

Дээрх шинэчлэл нь хорих ялын нийгэмд үзүүлэх үр нөлөө нь төдийлөн өндөр байдаггүйг дэлхий нийт хүлээн зөвшөөрч аль болох хорихоос өөр төрлийн ялыг сонгож, гэмт хэргийн шинж байдлаас нь шалтгаалан ялыг ялгамжтай оногдуулж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэр бүл, хамт олон, нийгэмд нь байлгаж, гэмт хэргийн нийгмийн хор аюулыг ухамсарлуулахад чиглэсэн ялын бодлогыг баримтлах хандлагатай байгаагаас хамааралтай гэж үзэж болохоор байна.

Судлаач би шинэчлэн батлагдсан эрүүгийн хуулийн эрүүгийн хариуцлагын төрөл болох үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг эрдэмтэн судлаачид хэрхэн тайлбарласныг судалж үзэхэд академич С.Нарангэрэл, доктор С.Жанцан нар зөвхөн албадлагын арга хэмжээний ерөнхий ойлголтын түвшинд эдгээрийн уламжлалт төрөл болох эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг тусгайлан авч судалсан ба академич С.Нарангэрэл⁵⁵ албадлагын арга хэмжээний уламжлалт төрөл болох эмнэлгийн болон хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний төрлийг хууль зүйн эх үүсвэр, үндсэн шинж онцлог болон хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг зан суртахууны ба материаллаг шинжтэй арга хэмжээ хэмээн ангилан авч үзсэн байдаг.

Харин доктор С.Жанцан⁵⁶ албадлагын арга хэмжээг эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ хэмээнэ тодорхойлж “эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ гэдэг нь гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдсон этгээдэд шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулдаг, ялын бус шинжтэй, Эрүүгийн хуульд заасан төрийн албадлагын арга хэмжээний төрлийг хэлнэ” гэж тодорхойлсон ба албадлагын арга хэмжээний төрөлд эмнэлгийн болон хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хамааруулж тэдгээрийн хууль зүйн үндэслэл, үндсэн шинжийг тодорхойлсон байдаг.

Доктор /Ph.D/ Д.Бадам⁵⁷ Тэнсэх албадлагын арга хэмжээ, уламжлал, шинэчлэлийн асуудал өгүүлэлд “Албадлагын арга хэмжээ гэдэгт эрүүгийн ялын зорилгыг хангах, ялын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд шүүхийн шийтгэх тогтоолоор эрүүгийн хуулийн тусгай ангийн санкцид заасан ял оногдуулахгүйгээр тэнсэж эсхүл оногдуулсан ял дээр нэмж ялтанд тусгай үүрэг хүлээлгэх, эрхийн хязгаарлалт тогтоохыг хэлнэ” гэж албадлагын арга хэмжээг өмнөх эрдэмтдийн тодорхойлсноос өргөн хүрээнд авч үзэж албадлагын арга хэмжээний бие даасан шинэ төрөл болох үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээний шинж онцлогийг тодотгожээ.

Дээрх эрдэмтдийн судалгаанаас болон урьд үйлчилж байсан Эрүүгийн хуульд хуульчлагдсан байдлыг судалж үзэхэд үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээний зөвхөн үүрэг хүлээлгэх арга хэмжээг хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд тусгайлан хүлээлгэх маягаар хамтатган хэрэглэж байсан гэж үзэж болохоор байна.

⁵⁵ С. Нарангэрэл. Монгол Улсын эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. УБ. 1999.362-370 дахь тал

⁵⁶ С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол. /Ялын тухай сургаал/ 2-р боть. УБ.2014. 325 дахь тал

⁵⁷ Д.Бадам. Тэнсэх, албадлагын арга хэмжээ: Уламжлал, шинэчлэлийн асуудал. Хууль дээдлэх ёс, Хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, практикийн улирал тутмын сэтгүүл. УБ.2016,3 (58) 79 дэх тал

2015 онд батлагдсан Эрүүгийн хуульд хорихоос өөр төрлийн ялын зорилгыг гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэр бүл, нийгэм, хамт олны дунд нь байлгаж, гэмт хэргийн нийгмийн хор аюулыг ухамсарлуулан ойлгуулах, өөрийн хөдөлмөрөөр нь нийгэм, иргэдэд учруулсан хохирлыг барагдуулах, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино гэж томьёолсон.

Уг ялыг шүүхээс оногдуулж буй байдлыг судалж үзэхэд Улсын дээд шүүхийн 2021 оны тайланд эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолын 27%-ийг хорих ялаар шийтгэсэн тогтоол эзэлж байна. Судалгаанаас харахад 63% нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрүүгийн хуулийн ялын бодлогын хүрээнд торгох, нийтэд тустай ажил хийлгэх, эрх хасах, зорчих эрхийг хязгаарлах ял, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх албадлагын арга хэмжээ оногдуулсан байна.

Монгол Улс мөн дэлхий нийтийн жишгээр гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан 2017 оны “Эрүүгийн хуулийн хууль”-д тэнссэн этгээдэд нэмэлтээр эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхээр хуульчилсан.

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлагдсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, 2017 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгаар 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хуучин Цагдаагийн байгууллагын хяналтад байсан хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн, хорих ялаас хугацааны өмнө суллагдаж хяналт тогтоосон, эрх хязгаарлах болон үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд тавих хяналтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлж эхэлсэн.

Албадлагын арга хэмжээг дотор нь үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ гэж ангилан үзэх бөгөөд хэрэгжилтийг хангахад төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо зайлшгүй шаардлагатай байдаг. Тухайлбал эрх хязгаарлах, үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээний нэг төрөл болох зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтыг явуулахад мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо хандлага чухал байдаг.

Харин гадаадын зарим орнуудад уг арга хэмжээг албадлагын бус харин “аюулгүйн, хүмүүжлийн, нөлөөллийн” арга хэмжээ гэсэн нэр томьёоллоор Эрүүгийн хуульдаа хуульчлан шүүхийн практиктаа түгээмэл хэрэглэдэг байна.

Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг гадаадын орны жишиг хандлага болон олон улсын баримт бичиг, Тухайлбал “Хорихоос бусад төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм”-д нийцүүлэн эрх

зүйн зохицуулалтыг өөрчилж боловсронгуй болгох зайлшгүй шаардлага тулгарч байна.

Гадаадын зарим оронд хорихоос өөр төрлийн ялын олон төрөл, хэлбэр байна. Тухайлбал, гэрийн хорионд байлгах, эд хөрөнгө хураах, нийтэд тустай ажил хийлгэх, түр хугацаагаар албадан эмчлэх, тодорхой албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрх хасах, цол, одон медаль хураах, нутаг заах, сонгох, сонгогдох эрх хасах, гадагшаа зорчих эрхийг нь хязгаарлах, ан агнах эрхийг хасах, эдийн засгийн эрхийг хязгаарлах гэх мэт маш олон төрлийн ялыг оногдуулж байна.

Шүүхээс эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд заасны дагуу гаргасан шийтгэх тогтоол, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар гаргасан шийдвэр нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар хэрэгждэг байна. Эрүүгийн хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа түүний дотор хорихоос өөр төрлийн ялын гүйцэтгэх шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь онцлог байдлаар хэрэгждэг ба ял эдлүүлэх ажиллагааны онцлогоос хамаарч түүнд тавих хяналтын тогтолцоо ч мөн адил өвөрмөц онцлогтой байдаг байна.

Манай орны хувьд шүүгч, прокуроруудын дунд уг албадлагын арга хэмжээг ямар хугацаагаар хэрхэн хэрэглэх талаар нэгдсэн ойлголтгүйгээс хуульд тусгасан албадлагын арга хэмжээг янз бүрээр хэрэглэж, хүний эрхийг зөрчих эсхүл албадлагын арга хэмжээг төдийлөн оногдуулахгүй тэнсэгдсэн болон ял хойшлогдсон этгээдэд хэлбэр төдийгөөр хэрэглэж байгаа нь эрх зүйн зохицуулалт талаас судалж үзэхэд хийдэлтэй, хэм хэмжээний зөрчилтэй заалтууд ихтэй, гэмт хэрэг үйлдсэн хүнд хүлээлгэх Эрүүгийн хуулиар хуульчлагдсан үүргүүд тодруулбал зан үйлээ засах, хөдөлмөр дадал олгох сургалтад хэрхэн хамрагдах талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгайлан хуульчлаагүй, тодорхой газар очих тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах асуудалд шийдвэр гүйцэтгэгч биечлэн хяналт тавих төдийлөн боломжгүй, техник хэрэгсэл ашигладаггүй талаар эрх зүйн зохицуулалт дутмаг байдаг.

Уг хяналтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлж эхэлснээр Улаанбаатар хот, аймгийн хэмжээнд нэг шийдвэр гүйцэтгэгчид ноогдох хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн болон тэнссэн, хорих ялаас хугацааны өмнө суллагдаж хяналт тогтоогдсон, эрх хязгаарлах болон үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд тавих хяналтаар ажлын ачаалал ихэссэнтэй холбогдуулж практикт маш олон хүндрэл бэрхшээлүүд гарч ирсэн ба 2017 онд 243 этгээд, 2018 онд 1670 этгээд, 2019 онд 3584 этгээд, 2020 онд 4701 этгээдэд үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд хяналт тавьж ажилласан байна.

Гэвч дээрх этгээдүүдэд сургалт зохион байгуулах хяналт тавьж ажиллахад хүн хүч, хөрөнгө мөнгө, мэргэжлийн багш, сэтгэл зүйч, нийгмийн ажилтны орон тоо дутмаг төвлөрсөн хорих ангитай газарт нийгмийн ажилтан сэтгэл зүйч, хорихоос өөр төрлийн ял хариуцсан шийдвэр гүйцэтгэгч нь сургалт ордог боловч алслагдсан сум, шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст тухайн нийгмийн ажилтан сэтгэл зүйч байдаггүй, хорихоос өөр төрлийн гүйцэтгэгч нь үүрэг хүлээлгэх эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд сургалт явуулдаг ба хамтран ажиллаж байгаа төрийн бус байгууллагуудын оролцоо хангалтгүй хүрэлцээ багатай зэрэг хүндрэлтэй асуудлууд үүсдэг.

Цаашид сумдад байгаа эрх хязгаарлах, үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд тавих хяналт, зохион байгуулах нийгэмшүүлэх сургалт, тэдгээрт төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоо тэдгээрийн хамтын ажиллагаа, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан гүйцэтгэгч нь хорихоос өөр төрлийн ял албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд хяналт тавьж ажиллаж байгаа боловч практикт эрх хязгаарлах, үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд эрх зүйн зохицуулалтын болон удирдлага зохион байгуулалтын тулгамдсан асуудал нэлээдгүй байна.

Дүгнэлт

Шинэ эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэмт хэргийн шинж чанар, хор уршгаас хамаарч оногдуулсан ял дээр нэмж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ /тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах, галт зэвсэг өмчлөх, эзэмшихийг хориглох, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох, тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулахыг хориглох/ оногдуулахаар заасан нь давуу талтай хэдий ч хуулийн хэрэгжилтийг хангахад учир дутагдалтай зүйлүүд байсаар байна.

Хуулиа дагаад журам гарч хэрэгжих ёстой байтал өнөөдрийг хүртэл эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой ойлголтод хүрээгүй, хэлбэрийн төдий хэрэгжсээр байгаа юм. Тухайлбал,

➤ “тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах” энэ төрлийн эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг ихэвчлэн эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэг “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-т давхар эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг хэрэглэж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага энэ төрлийн эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хохирогч, түүний төрөл төрөгсдөөс мэдүүлэг авах замаар хяналтыг хэрэгжүүлдэг нь өөрөө хохирогчид тухай гэмт хэргийн дахин дахин сануулах, сэтгэл зүйн хувьд асар их дарамт учруулж байдаг. Уг нь энэ төрлийн албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 189 дүгээр зүйлийн “189.10.Үүрэг хүлээлгэх, эрх

хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд энэ хуулийн 167 дугаар зүйлд заасан журмын дагуу техникийн болон биечилсэн хяналт тавьж болно” зааж өгсөн боловч хэрэглэх журам байхгүй улмаас царцаад удаж байна.

Эрх хязгаарлах албадлагын арга хэмжээний гол тулгуур зохицуулалт нь Зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын системд хөгжүүлэлт хийгдэж техник төхөөрөмж сайжирсанаар албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд бүрэн хяналт тавих, гэмт хэргийн хохирогчид дахин гэмт халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлэх юм.

Эх сурвалжийн жагсаалт

1. С. Нарангэрэл. Монгол Улсын эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. УБ. 1999 он
2. С. Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол. /Ялын тухай сургаал/ 2-р боть. УБ. 2014 он
3. Д. Бадам. Тэнсэх, албадлагын арга хэмжээ: Уламжлал, шинэчлэлийн асуудал. Хууль дээдлэх ёс, Хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, практикийн улирал тутмын сэтгүүл. УБ. 2016, 3 (58)

---o0o---